

# Хайрла, хуваалц, урь

## Хайрлах

Иохан 13:34–35; Мозая 18:20–22; Сургаал ба Гэрээ 12:7–9; 121:41–42

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Гари Э.Стивэнсон ийн заасан.



Бид хөршдөө нэг ч үг хэлээгүй байсан ч Христийнхтэй адил хайрыг харуулах бүрдээ сайн мэдээг номлож байдаг.

Бусдыг хайрлах нь хөршөө хайрлах хоёр дахь агуу тушаалын тод томруун илэрхийлэл бөгөөд энэ нь бидний сэтгэл дотор явагдаж буй Ариун Сүнсний цэвэршүүлэх үйл явцыг харуулдаг. Бид Христэй адил бусдыг хайрласнаар бидний сайн үйлсийг хардаг хүмүүсийг “тэнгэр дэх [бидний] Эцэгийг алдаршуулахад” [Матай 5:16] хүргэж чадна. (Гари Э.Стивэнсон, “Хайрла, хуваалц, урь,” *Лиахона*, 2022 оны 5-р сар, 84–87)

## Хуваалцах

2 Нифай 2:6–8; Мозая 28:1–3; Алма 31:5; Сургаал ба Гэрээ 60:2

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф ийн заасан.



Хэрэв хэн нэгэн танаас амралтын өдрөөрөө юу хийснийг тань асуувал сүм дээр юу тохиолдсоноо хуваалцахаас бүү татгалз. Хүмүүсийн өмнө гараад Есүстэй адилхан болохыг хэрхэн хичээж байгаа тухай дуулсан хүүхдүүдийн талаар хэлээрэй. Та мөн ахмадын асрамжийн газарт очиж нас дээр гарсан хүмүүст хувийн түүхийг нь эмхэтгэн цуглуулахаар цаг гарган тусалсан өсвөр үеийнхний талаар яриарай. . . .

Өөрийнхөө хувьд хамгийн энгийн, эвтэйхэн гэсэн байдлаар Есүс Христ болон Түүний Сүм яагаад танд чухал болохыг хүмүүстэй хуваалц. (Дийтр Ф.Угдорф, “Номлолын ажил бол зүрх сэтгэл доторхоо хуваалцах явдал юм,” 2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 17)

## Урих

Иохан 1:35–46; 4:28–30, 39–41; Алма 5:62; Моронай 10:3–5

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Гари Э.Стивэнсон ийн заасан.



Бидэнд бусдад өгч чадах олон зуун урилга байдаг. Бид бусдыг Есүс Христийн сайн мэдээг тайлбарладаг онлайн видео, ариун ёслолын цуглаан, тойргийн үйл ажиллагаа зэргийг “ирээд, харахад” урьж болно. Мөн “ирээд, харах” гэдэгт ариун сүмийг онцгойлон адислахаас өмнөх нээлттэй хаалганы өдөрлөгт зочлох, Мормоны Номыг унших зэрэг урилгууд орж болно. Зарим тохиолдолд өөрсдөдөө байгаа, тухайлбал эргэн тойронд байгаа боломжуудаа анхаарч хараад, тэдгээрийн дагуу үйлдэхийг сануулах замаар урилга өгдөг. (Гари Э.Стивэнсон, “Хайрла, хуваалц, урь,” *Лиахона*, 2022 оны 5-р сар, 84–87)